Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзээд, 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлаас тооцоход гүйцэтгэлийн материаллаг байдал 7,287.5 мянган төгрөг байгаа тул, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Баянбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 59,811.0 мянган төгрөгөөр буюу 7.6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгө болон өглөгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	131,354.3	109,657.3	(21,696.9)
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	9,897.6	-	(9,897.6)
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	121,456.7	109,657.3	(11,799.3)
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	657,118.9	738,626.9	81,508.0
Үндсэн хөрөнгө	847,210.4	954,900.9	107,690.5
Хуримтлагдсан элэгдэл	(190,091.5)	(216,274.0)	(26,182.5)
<b>Нийт хөрөнгө</b>	788,473.2	848,284.2	59,811.0
Өр төлбөр	-	1,200.2	1,200.2
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	788,473.2	847,084.0	58,610.9
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	788,473.2	848,284.2	59,811.0

Бараа материалын дансны үлдэгдэл 109,657.3 мянган төгрөг болж 11,799.3 мянган төгрөгөөр буурсан нь, бичиг хэргийн материал 220.9 мянга, аж ахуйн материал 4,412.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, тусгай зориулалтын материал 3,248.2 мянга, бусад хангамжийн материал 11,564.1 мянган төгрөгөөр буурсан нь голлох нөлөөг үзүүлж байна.

ААБ 5.5: АУДИТААР ИЛРҮҮЛСЭН АЛДАА, ЗӨРЧИЛТЭЙ АСУУДЛЫН БҮРТГЭЛ

Байгууллагын нэр: Гурванбулаг сумын ЗДТТ  
Тайлант хугацаа: 2021

№	Ажил гүйцэтгэлийн нийгэм, анги, дансанд	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Шалгагдагч байгууллагын санал, тайлбар	Аудитын байгууллагаас өгсөн хариу, тайлбар	Гаргасан шийдэл	Уйлчилуулагч байгууллагын талаас	
							Албан тушаал	Овог нэр
А		3	4	5	6	7	8	мянган төгрөгөөр
Мөнгөн хөрөнгө	1	71680.2	Албан шаардлага хүргүүлэх.	Зөрчлийг арилгах албан шаардлагыг хүлээн зөвшөөрч, заасан хугацаанд зөрчлийг арилгана.	Зөрчлийг 2021.11.25-ны дотор арилгах.	Арилжааны банкин дахь харилцах дансыг хааж, зөрчлийг цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөв.	Гурванбулаг сумын Засаг Тамгын газрын дарга, нягтлан бодогч	Р.Гантулаг, Б.Дэлгэрдалай
Мөнгөн хөрөнгө	1	6012.0	Зөвлөмж өгөх	Хүлээн зөвшөөрсөн. Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.	Зөвлөмжийн биелэлтийг 2022.05.30-ны дотор ирүүлэх.	Цаашид Сангийн сайдын 2017 оны "Маягт, заавар батлах тухай" 347 дугаар тушаалын холбогдох заалтыг мөрдөж ажиллаж байгаад удирдлагын зүгээс хяналт тавьж ажиллах.	Гурванбулаг сумын Засаг даргын Тамгын газрын дарга, нягтлан бодогч	Р.Гантулаг, Б.Дэлгэрдалай
Мөнгөн хөрөнгө	1	1333.3	Зөвлөмж өгөх	Хүлээн зөвшөөрсөн. Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.	Зөвлөмжийн биелэлтийг 2022.05.30-ны дотор ирүүлэх.	Цаашид Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан "Эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ыг бүрэн мөрдөж, батлагдсан төсвийн зориулалтын газрын дагуу зарцуулж, ажиллах зөвлөмжийг хүргүүлэв.	Гурванбулаг сумын Засаг даргын Тамгын газрын дарга, нягтлан бодогч	Р.Гантулаг, Б.Дэлгэрдалай
Мөнгөн хөрөнгө	1	352.0	Төлбөрийн акт тогтоох	Заасан хугацаанд төлбөрийн актыг барагдуулна.	Актын биелэлтийг 2022.01.25-ны дотор барагдуулах.	Төсвөөс илүү зарцуулсан 352.0 мянган төгрөгийг холбогдох буруутай албан тушаалтнуудаар төлүүлэх төлбөрийн акт тогтоов.	Гурванбулаг сумын Засаг даргын Тамгын газрын дарга, нягтлан бодогч	Р.Гантулаг, Б.Дэлгэрдалай
Мөнгөн хөрөнгө	1	0.0	Зөвлөмж өгөх	Хүлээн зөвшөөрсөн. Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.	Зөвлөмжийн биелэлтийг 2022.05.30-ны дотор ирүүлэх.	Цаашид Байгууллагын удирдлага нь хүчин төгөлдөр хууль эрхзүйн актыг мөрдөж байх зөвлөмжийг хүргүүлэв.	Гурванбулаг сумын Засаг даргын Тамгын газрын дарга, нягтлан бодогч	Р.Гантулаг, Б.Дэлгэрдалай
Мөнгөн хөрөнгө	1	67,626.9	Албан шаардлага хүргүүлэх.	Зөрчлийг арилгах албан шаардлагыг хүлээн зөвшөөрч, заасан хугацаанд зөрчлийг арилгана.	Зөрчлийг 2021.12.25-ны дотор арилгах.	Засаг даргын нөөц хөрөнгө, байгаль орчныг нөхөн сэргээх зардал болон гамшгаас сэргийлэх, сургалт сурталчилгааны зардлаас Гурванбулаг зарцуулсан 67,626,867 /Жаран долоон сая зургаан зуун хорин зургаан мянга найман зуун жаран долоон/ төгрөгийн хөрөнгийн зарцуулалтын тайланг гаргаж зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.	Гурванбулаг сумын Засаг даргын Тамгын газрын дарга, нягтлан бодогч	Р.Гантулаг, Б.Дэлгэрдалай

Шилэн данс	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд хуулийн 6.4.5-д заасан таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 17,084.8 мянган төгрөгийн зарлагын 1 гүйцэтгэг хугацаа хоцроосон байна.	-	Зөвлөмж өгөх	Хүлээн зөвшөөрсөн. Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.	Зөвлөмжийн биелэлтийг 2022.05.30 ны дотор ирүүлэх.	Цаашид Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д заасан мэдээллийг хугацаанд нь үнэн зөв байршуулж байх зөвлөмжийг өгөв.	Гурванбулаг сумын Засаг даргын Тамгын газрын дарга, нягтлан бодогч	Р.Гантулаг, Б.Дэлгэрдалай
Нийт зардал	2021 оны төсвийг 400,773.5 мянган төгрөгөөр анх баталсан ба тодотголоор 30,730.1 мянган төгрөг нэмж 430,503.6 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 1,000.0 мянган төгрөгийг төсөвт байгууллагын өөрийн орлогоор санхүүжүүлэхээр баталсан ба гүйцэтгэлээр 421,970.3 мянган төгрөг зарцуулж, орон нутгийн төсөвт 8,900.8 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байгаа нь нийт зардлын 2.1 хувийг хэмнэсэн гэж үзэхээр байгаа бөгөөд бичиг хэргийн зардалд хэмнэлт гаргаагүй байна.	-	Зөвлөмж өгөх	Хүлээн зөвшөөрсөн. Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.	Зөвлөмжийн биелэлтийг 2022.05.30 ны дотор ирүүлэх.	Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний талаар Засгийн арга хэргээс гаргасан тогтоол, журмуудыг даргын Тамгын газрын дарга, нягтлан бодогч хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.	Гурванбулаг сумын Засаг даргын Тамгын газрын дарга, нягтлан бодогч	Р.Гантулаг, Б.Дэлгэрдалай
9	2.0	-	147,004.4					

Бэлтгэсэн: Аудитор

Хянасан: Ахлах аудитор

Аудитын менежер:

Дарга, Тэргүүлэх аудитор

Гурванбулаг сумын ЗДТГ  
ТӨСВИЙН ЗАХИРАГЧ:

НЯГТЛАН БОДОГЧ:

Б.НАРАНГЭРЭЛ

М.АЛТАНТУЯА

А.ЦЭЭНЯМ

Б.МӨНХБАТ

Р.ГАНТУЛГА

Б.ДЭЛГЭРДАЛАЙ

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 954,900.9 мянган төгрөг болж 107,690.5 мянган төгрөгөөр өссөн нь шинэ сургууль ашиглалтад орсонтой холбоотойгоор БСШУЯ-аас 43894.9 мянган төгрөгийн өртөг бүхий тоног төхөөрөмж, аймгийн ЗДТГ-аас 5,605.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, мөн сургуулийн төгсөгчдийн зүгээс 36410.6 мянган төгрөгийн нийтийн эзэмшлийн зам талбай, сагсан бөмбөгийн талбай, гадна тохижилт зэргийг үнэ төлбөргүйгээр хүлээн авч, урсгал төсвийн худалдан авалтаар 20,300.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан. Мөн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 70 дугаар тогтоолоор 8,585.0 мянган төгрөгийн анхны өртөг бүхий барилга байгууламжийг акталсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 847,084.0 мянган төгрөг болж 58,610.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 58,610.9 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, зарлагыг 716,043.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 120,458.5 мянган төгрөгөөр бууруулж 595,584.7 мянган төгрөгөөр анх баталсан байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 12 арга хэмжээг санхүүжүүлэхээр 662,158.1 мянган төгрөгийн төсөв баталснаас 590,272.9 мянган төгрөгийг улсын төсвөөс, 71,885.2 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 590,272.9 мянга, орон нутгийн төсвөөс 71,257.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд зарцуулж, 4,820.4 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 636,794.3 мянган төгрөг буюу 99.2 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 1,804.1 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 628.0 мянга, хангамж, бараа материалын зардлыг 2,831.5 мянга, нормативд зардлыг 131.4, томилолт зочны зардлыг 49.3 мянган төгрөгөөр хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Тус байгууллага нь 2020-2021 оны хичээлийн жилд нийт 36 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж, бага, суурь боловсролын хамран сургалтын дундаж 96.4%, 2021-2022 оны хичээлийн жилийн хамран сургалт 93%-тай, мэргэжлийн багшийн хангалт 100% байгаа бөгөөд үйл ажиллагааны зардалд 662,158.1 мянган төгрөг батлагдсан байна.

Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Цэрэнчимэд санхүүгийн тайлангийн аудит хийсэн бөгөөд тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх оны санхүүгийн тайлангийн мэдээллийг хамруулаагүй болно.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд зорилго, 6 зорилтын хүрээнд 21 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж 93.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал 694,044.9 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 34,594.4 мянган төгрөгөөр буюу 8.5 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, эд хогшил, урсгал засварын зардал хангамж бараа материалын зардал, бараа үйлчилгээний бусад зардлууд нь өмнөх оноос нэмэгдсэн байгаа бол цалин, хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж, нормативд зардал, томилолт зочны зардлууд өмнөх оноос буурсан үзүүлэлттэй байна.

2021 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 160 хүүхдийн сургуулийн барилгыг ашиглалтад хүлээн авсан ч одоогоор хөрөнгөд бүртгэж аваагүй байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл”-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тус байгууллага нь 2021 онд нийт 850,042.8 мянган төгрөгийн 67 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод мэдээлэхээс 6.1.2-д заасан төсвийн гүйцэтгэлийн мэдээг 3 дугаар улирал, 6.1.4-д заасан санхүүгийн тайлан /хагас жил/, 6.4.5-д заасан таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 120,210.7 мянган төгрөгийн орлогын 5 гүйлгээг хугацаа хоцроосон бөгөөд 6.1.2-д заасан төсвийн гүйцэтгэлийн мэдээг 4 дугаар улирал, 6.4.3-д заасан 3 мэдээллийг мэдээлээгүй байна.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

### **Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилт**

Байгууллагын төсвийн хөрөнгийн зарцуулалтад тогтоолын хэрэгжилтийг шалгахад дараах байдалтай байна. Үүнд:

- 2021 оны төсвийг анх 595,584.7 мянган төгрөгөөр баталсан ба тодотголоор 66,573.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн баталснаас 590,272.9 мянган төгрөгийг улсын төсвөөс, 71,885.2 мянган төгрөгийн мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр тодотгон баталсан ба гүйцэтгэлээр 656,709.7 мянган төгрөг зарцуулж, улсын төсөвт 29,510.2 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байгаа нь нийт зардлын 4.5 хувийг хэмнэсэн гэж үзэхээр байна.

Энэ нь Энэ нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1<sup>1</sup> гэсэн заалттай нийцэхгүй байна.

- Байгууллагын ашиглалттай холбоотой тогтмол зардлын төсвийг анх 48,368.1 мянган төгрөгөөр, тодотголоор 70885.2 мянган төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 70257.2 мянган төгрөг зарцуулж анх баталсан дүнгээс 21,889.1 мянган төгрөг буюу 45.3 хувиар нэмэгдүүлсэн.

Энэ нь Энэ нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1<sup>2</sup> гэсэн заалттай нийцэхгүй байна.

- Бичиг хэргийн зардлыг 810.5 мянган төгрөгөөр баталснаас гүйцэтгэлээр 470.0 мянган төгрөг зарцуулсан нь дээрх тогтоолтой нийцэж байна.

#### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 2 зөвлөмжийг өгснийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

#### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй**

### **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 3,213.2 мянган төгрөгийн 7 алдаа зөрчил илэрснээс, 150.0 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1,684.9 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 1,378.3 мянган төгрөгийн зөрчилд 5 зөвлөмжийг хүргүүллээ.

#### **4.1 Төлбөрийн акт**

1. Тус сургуулийн захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Болор-эрдэнэ нь өөр дээрээ тушаал гаргаж түлшний хөнгөлөлт болох 150.0 мянган төгрөгийг авсан байна.

Энэ нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 "Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг

1. Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах

2. байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд 20-иос доошгүй хувийн хэмнэлт гаргах;

үйл ажиллагаа явуулахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Дээрх хууль зөрчиж олгосон 150.0 мянган төгрөгийг холбогдох буруутай албан тушаалтнаар буцаан төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

#### 4.2 Албан шаардлага

1. Тайлант онд 1684.9 мянган төгрөгийн шатахууныг жолоочийн тооцооны хуудасгүйгээр зарлага гаргасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна.” 20.2.3 “Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэсэн заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн “Иж бүрэн байх”, “Үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Дээрх жолоочийн тооцооны хуудасгүйгээр зарлага гаргасан зөрчлийг арилгах албан шаардлага өгөв.

#### 4.3 Зөвлөмж

1. Няравын тайлан болон бараа материалын журналыг тулгахад шатахууны тайланг 619.5 мянга, дотуур байрны хүүхдийн хоол хүнсний тайланг 396.0 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” гэсэн заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Цаашид няравын тайланг сар бүр хянаж, хүлээн авч, анхан шатны баримтад үндэслэн санхүүгийн тайланг гаргаж байх зөвлөмжийг хүргүүлэв.

2. Цалингийн зардлыг давтан тооцоолоход тус сургуулийн захиралд сумын Засаг даргын захирамжаар 1,2,4 дүгээр саруудад ур чадварын нэмэгдлийг 20 хувиар олгох байтал 4 дүгээр сард 40 хувь буюу 362.8 мянган төгрөгийг илүү олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “үнэн зөв байх” гэсэн заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Санхүүгийн тайлангийн завсрын үеийн аудитаар илэрсэн дээрх зөрчлийг холбогдох албан тушаалтнаас суутган тооцох зөвлөмжийг хүргүүлэв.

3. Тус сумын ерөнхий боловсролын сургуулийг 2020.11 дүгээр сард шинээр барьж ашиглалтад оруулсан бөгөөд одоогоор хуучин сургуулийн барилгыг ажилчдын орон сууцаар ашиглаж байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.1 “Өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах” гэсэн заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Цаашид тус барилгын ашиглалтыг сайжруулж, холбогдох байгууллагад хандаж шийдвэрлүүлэх зөвлөмжийг хүргүүлэв.

4. Тус байгууллагын төсвийн гүйцэтгэлийн тайланг тулгахад анх 595584.7 мянган төгрөгөөр баталсан бөгөөд 2021 оны 12 дугаар сард 66,573.4 мянга буюу 11.6 хувиар нэмэгдүүлэн 662158.1 мянган төгрөгөөр тодотгон баталсан байна. Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг анх баталснаас 45.3 хувиар нэмэгдүүлсэн. Мөн төсвийн хөрөнгөөр 20,000,0 төгрөгийн тавилга хэрэгсэл, тоног төхөөрөмж худалдан авсан байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоолын 1.4 “Энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх” гэсэн заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Цаашид Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоолыг хэрэгжүүлж, дээд шатны байгууллагаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг хүргүүлэв.

5. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд хуулийн 6.1.2-д заасан төсвийн гүйцэтгэлийн мэдээг 3 дугаар улирал, 6.1.4-д заасан санхүүгийн тайлан /хагас жил/, 6.4.5-д заасан таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 120,210.7 мянган төгрөгийн орлогын 5 гүйлгээг хугацаа хоцроосон бөгөөд 6.1.2-д заасан төсвийн гүйцэтгэлийн мэдээг 4 дугаар улирал, 6.4.3-д заасан 3 мэдээллийг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2 –д заасан “хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор, өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, сар, улирлын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор”, 6.1.4 “Жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, хагас жилийн тайланг 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор”, 6.4.3 “Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан”, 6.4.5 “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн, санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Цаашид Шилэн дансны тухай хуульд заасан мэдээлбэл зохих мэдээллүүдийг цаг хугацаанд нь үнэн зөв мэдээлж байх зөвлөмжийг хүргүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Баянбулаг сумын Ерөнхий боловсролын сургууль	7	3213.2	0	0	1	150	1	1684.9	5	1378.3

Ажлын баримтын нэр:	Залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа, зөрчилтэй асуудлын бүртгэл
Ажлын баримтын дугаар	Б501
Аудитын код:	0
Аудитын нэр:	Баянбулаг сумын Ерөнхий боловсролын сургууль

№	Аудитын чиглэл	Тоо	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Уйлчлүүлэгч байгууллагын талаас алдаа, зөрчилтэй асуудлыг харуулах хүний	
						Албан тушаал	Овог нэр
А	1	2	3	4	5	6	7
1	Баланс	1	Шатахууны тайланд 1684.9 мянган төгрөгийн шатахууныг замын хуудасгүйгээр зарлагдсан байна.	1,684.9	Албан шаардлага өгөх	Баянбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирлын түр хавсран гүйцэтгэгч, нягтлан бодогч	Д.Болор-Эрдэнэ, С.Ганболд
2	Баланс	1	Няравын тайлан болон бараа материалын журналыг тулгахад шатахууны тайланг 619.5 мянга, дотуур байрны хүүхдийн хоол хүнсний тайланг 396.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан.	1,015.5	Зөвлөмж	Баянбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирлын түр хавсран гүйцэтгэгч, нягтлан бодогч	Д.Болор-Эрдэнэ, С.Ганболд
3	Зардал	1	Цалингийн зардлыг давтан тооцоолоход тус сургуулийн захиралд сумын Засаг даргын захирамжаар 1,2.4 дүгээр саруудад ур чадварын нэмэгдлийг 20 хувиар олгох байтал 4 дүгээр сард 40 хувь буюу 362838 төгрөгийг илүү олгосон байна.	362.8	Зөвлөмж	Баянбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирлын түр хавсран гүйцэтгэгч, нягтлан бодогч	Д.Болор-Эрдэнэ, С.Ганболд
4	Баланс	1	Тус сумын ерөнхий боловсролын сургуулийг 2020.11 дүгээр сард шинээр барьж ашиглалтад оруулсан бөгөөд одоогоор хуучин сургуулийн барилгыг ажилчдын орон сууцаар ашиглаж байгаа бөгөөд цаашид тус барилгын ашиглалтыг сайжруулж, холбогдох байгууллагад хандаж шийдвэрлүүлэх.	-	Зөвлөмж	Баянбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирлын түр хавсран гүйцэтгэгч, нягтлан бодогч	Д.Болор-Эрдэнэ, С.Ганболд
5	Зардал	1	Тус сургуулийн захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Болор-эрдэнэ нь өөр дээрээ тушаал гаргаж түлшний хөнгөлөлт болох 150.0 мянган төгрөгийг авсан байна.	150.0	Төлбөрийн акт	Баянбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирлын түр хавсран гүйцэтгэгч, нягтлан бодогч	Д.Болор-Эрдэнэ, С.Ганболд
6	Шилэн данс	-	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд хуулийн 6.1.2-д заасан төсвийн гүйцэтгэлийн мэдээг 3 дугаар улирал, 6.1.4-д заасан санхүүгийн тайлан /хагас жил/, 6.4.5-д заасан таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 120,210.7 мянган төгрөгийн орлогын 5 гүйцэтгэгч хугацаа хоцроосон бөгөөд 6.1.2-д заасан төсвийн гүйцэтгэлийн мэдээг 4 дугаар улирал, 6.4.3-д заасан 104, мянган төгрөгийн 3 мэдээллийг мэдээлээгүй байна.	-	Зөвлөмж	Баянбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирлын түр хавсран гүйцэтгэгч, нягтлан бодогч	Д.Болор-Эрдэнэ, С.Ганболд
7	Зардал	1	Тус байгууллагын төсвийн гүйцэтгэлийн тайланг тулгахад анх 595584.7 мянган төгрөгөөр баталсан бөгөөд 2021 оны 12 дугаар сард 66,573.4 мянга буюу 11.6 хувиар нэмэгдүүлэн 662158.1 мянган төгрөгөөр тодотгон баталсан байна. Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг анх баталснаас 45.3 хувиар нэмэгдүүлсэн. Мөн төсвийн хөрөнгөөр 20,000.0 төгрөгийг тавилга хэрэгсэл, тоног төхөөрөмж худалдан авсан байна.	3,213.2	Зөвлөмж	Баянбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирлын түр хавсран гүйцэтгэгч, нягтлан бодогч	Д.Болор-Эрдэнэ, С.Ганболд
7	-	6	-	3,213.2	-	-	-

Бэлтгэсэн: Аудитор

Анхан шатанд хянасан:  
Аудитын менежер:

Хоёр дахь шатанд хянасан:  
Дарга, Тэргүүлэх аудитор

Б.Нарангэрэл Төсвийн захирагч:

А.Цэцэням  
Нягтлан бодогч

Б.Мөнхбат

Баянбулаг сумын Ерөнхий боловсролын сургууль-ийн  
Д.Болор-Эрдэнэ, С.Га  
С.Ганболд